

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2018 оны..... дугаар сарын ...ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

МАЛ, АМЬТНЫ ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙГ БҮРТГЭХ, ХУДАЛДАХ, ЭГҮҮЛЭН ТАТАХ, ИМПОРТЫН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эх орны үйлдвэрийн болон импортын тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах, эгүүлэн татах тэдгээрт хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг мал, амьтны тэжээлийн нэмэлтийн үйлдвэрлэл, импорт, түүгээр худалдаа, үйлчилгээ эрхэлдэг байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж дагаж мөрдөнө.

1.3. Журмаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан харилцааг зохицуулна.

Хоёр. Тэжээлийн нэмэлтийг бүртгэх, өөрчлөлт оруулах, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаа

2.1. Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн асуудлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Малын эмийн салбар зөвлөл (цаашид "Эмийн зөвлөл" гэх) шийдвэрлэнэ.

2.2. Тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, хэлбэр, тун тус бүрээр нь улсын бүртгэлд нэг удаа бүртгэнэ.

2.3. Тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд 5 жилийн хугацаатай бүртгэж, гэрчилгээ олгоно.

2.4. Улсын бүртгэлд бүртгүүлсэн тэжээлийн нэмэлтийн хаяг шошго, савлалт, хэлбэр, технологид өөрчлөлт орсон тохиолдолд дахин бүртгэнэ.

2.5. Тэжээлийн нэмэлтийг бүртгүүлэхдээ үйлдвэрлэгч болон албан ёсны төлөөлөгч нь дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлэн Эмийн зөвлөлд ирүүлнэ. Үүнд:

2.5.1. Эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүн бүртгэхэд бүрдүүлэх материал:

-Тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг хүссэн өргөдөл (хавсралт1), албан бичгийн хамт;

-Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

-Тухайн бүтээгдэхүүний чанарыг шалгах арга аргачлал бүхий фармакофейн өгүүлэл;

-Тухайн бүтээгдэхүүнд орсон түүхий эдүүдийн нэр, гарал үүслийн болон чанарын гэрчилгээ;

-Бүтээгдэхүүний орц, найрлагын мэдээлэл;

-Бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүд; (афлатоксин, мөөгөнцөр, хүнд металл, даавар, антибиотик, өсөлтийг түргэсгэх бэлдмэл, нянгийн тэсвэрлэх чанарын үнэлгээ)

-Тэжээлийн нэмэлтийн үйлчлэл, үлдэгдлийн түвшин, сөрөг нөлөөний талаарх судалгааны материал;

-Байгалийн болон биологийн гаралтай түүхий эдийн нэр, төрөл, зүйлийг латин нэрээр бичсэн, тухайн бүтээгдэхүүнийг гаргаж авсан технологийн танилцуулга;

-Тэжээлийн нэмэлтийн найрлагад хувиргасан организм орсон бол түүнийг тодорхойлсон баримт бичиг;

-Бүтээгдэхүүний дээж;

-Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын лабораторийн сорилтын дүн;

-Шошгоны загвар;

-Тухайн тэжээлийн нэмэлтийн найрлага, химийн шинж чанар, хэрэглэх, хориглох заалт, гаж нөлөө, харилцан үйлчлэл, тун хадгалах нөхцөл, сэрэмжлүүлэг зэргийг тусгасан баталгаажсан загварын дагуу бичигдсэн хэрэглэх заавар; /Монгол хэл дээр/

2.5.2. Импортын бүтээгдэхүүн бүртгэхэд бүрдүүлэх материал:

-Тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг хүссэн өргөдөл (хавсралт 2), албан бичгийн хамт;

-Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

-Тухайн бүтээгдэхүүний чанарыг шалгах арга аргачлал бүхий фармакопейн өгүүлэл;

-Тухайн бүтээгдэхүүнд орсон түүхий эдүүдийн нэр, гарал үүслийн болон чанарын гэрчилгээ;

-Үйлдвэрлэгчийн шошгоны загвар; (цахимаар шалгаж баталгаажуулна)

-Тухайн тэжээлийн нэмэлтийн найрлага, химийн шинж чанар, хэрэглэх, хориглох заалт, гаж нөлөө, харилцан үйлчлэл, тун хадгалах нөхцөл, сэрэмжлүүлэг зэргийг тусгасан баталгаажсан загварын дагуу бичигдсэн хэрэглэх заавар; /Монгол хэл дээр/

-Бүтээгдэхүүний орц, найрлагын мэдээлэл;

-Бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүд; (афлатоксин, мөөгөнцөр, хүнд металл, гормон, антибиотик, өсөлтийг түргэсгэх бэлдмэл, нянгийн тэсвэрлэх чанарын үнэлгээ)

-Тэжээлийн нэмэлтийн үйлчлэл, үлдэгдлийн түвшин, сөрөг нөлөөний талаарх судалгааны материал;

-Байгалийн болон биологийн гаралтай түүхий эдийн нэр, төрөл, зүйлийг латин нэрээр бичсэн, тухайн бүтээгдэхүүнийг гаргаж авсан технологийн танилцуулга;

-Тэжээлийн нэмэлтийн найрлагад хувиргасан организм орсон бол түүнийг тодорхойлсон баримт бичиг;

-Бүтээгдэхүүний дээж;

-Хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн;

-Экспортлогч орны тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчтэй буюу албан ёсны дистрибьютертэй байгуулсан гэрээний эх хувь;

-Үйлдвэрлэгч улсын гарал үүслийн ба бүртгэлийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар;

-Үйлдвэрлэгч улсын эрх бүхий лабораторийн шинжилгээний дүн;

-Үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/

-Импортын тэжээлийн нэмэлтийг бүртгэхэд зөвхөн үйлдвэрлэгчээс ирүүлсэн эх бичиг баримтыг үндэслэх бөгөөд гараар бичсэн, тамга тэмдэггүй, факсаар ирүүлсэн, интернэтээс татаж авсан материалыг шаардлага хангахгүйд тооцно.

2.6. Тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн хугацааг сунгах

2.6.1. Бүртгэлийг анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгана.

2.6.2. Хэрэглэгчээс гаргасан гомдол нотлогдоогүй, технологид өөрчлөлт ороогүй, эрх бүхий хөндлөнгийн лабораторийн сорилтын дүнтэй нэмэлтийг зөвлөлийн хуралдаанд танилцуулан бүртгэлийн хугацааг сунгана.

2.6.3. Нэмэлтийн бүртгэлийн хугацааг сунгасан тохиолдолд уг нэмэлтийн бүртгэлийн дугаар кодыг давтан хэрэглэнэ.

2.7. Дараах тохиолдолд тэжээлийн нэмэлтийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна.

2.7.1. Тухайн нэмэлтийн үйлдвэрийн өмчлөлийн хэлбэр, харьяалал, нэр, хаяг өөрчлөгдсөн;

2.7.2. Үйлдвэрийн технологи, фармакопей, хэрэглэх заавар, тун өөрчлөгдсөн;

2.8. Дараах тохиолдолд тэжээлийн нэмэлтийн бүртгэлийг түдгэлзүүлнэ.

2.8.1. Цуврал бүрийг шалгалтад хамруулаагүй;

2.8.2. Бичиг баримт нь хуурамчаар үйлдэгдсэн байж болзошгүй;

2.8.3. Эрх бүхий хөндлөнгийн лабораторийн дүгнэлтийг үйлдвэрлэгч, импортлогч нь хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд лавлагаа лабораториор баталгаажуулах хүртэлх хугацаанд;

2.8.4. Тухайн нэмэлтийн үлдэгдлийн түвшин нь хэрэглээний явцад зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн нь тогтоогдсон

2.9. Дараах тохиолдолд тэжээлийн нэмэлтийг бүртгэлээс хасах, хүчингүй болгох

2.9.1. Тухайн тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн хугацаа дууссан;

2.9.2. Бүртгэлд орсон тэжээлийн нэмэлтийг хэрэглэх явцад гаж ба сөрөг нөлөө илэрсний улмаас мал, амьтан үхсэн, удаан хугацаагаар эмчлүүлсэн нь нотлогдсон тохиолдолд салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр бүртгэлийг хүчингүй болгоно;

2.9.3. Тухайн үйлдвэрлэгч нэмэлтийг хуурамчаар үйлдвэрлэсэн болох нь нотлогдсон;

2.9.4. Бичиг баримт нь хуурамчаар үйлдэгдсэн болох нь нотлогдсон; /тогтоогдсон/

2.9.5. Эрх бүхий хөндлөнгийн лабораторийн дүгнэлтгүй чанарын баталгаагүй нэмэлтийг худалдаалсан тохиолдолд;

2.9.6. Тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө бүртгүүлэгч нь хугацаа сунгуулах хүсэлтээ Эмийн зөвлөлд ирүүлэх ба дурдсан хугацаанд хүсэлтээ ирүүлээгүй бол хүчингүйд тооцно;

2.9.7. Олон улс болон бүс нутагт хэрэглээнээс хасагдсан;

2.9.8. Бүртгүүлэгч нь тэжээлийн нэмэлтийг мал, амьтны аливаа өвчнийг эмчлэх үйлчилгээтэй мэтээр нийтэд сурталчлах болон бусад хууль журмыг зөрчсөн сурталчилгаа явуулсан тохиолдолд эмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр бүртгэлийг хүчингүй болгоно;

2.10. Тухайн нэмэлтийг бүртгэлээс хассан тухай мэдээллийг Эмийн зөвлөлийн шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан бүртгүүлэгч талд албан бичгээр хүргүүлнэ;

2.11. Бүртгэлийн гэрчилгээг нэг хувь үйлдэж бүртгүүлэгчид олгох ба хуулбарыг хэрэглэх зааврын хамт баталгаажуулан малын эмийн салбар зөвлөлд архивлан хадгална.

2.12. Бүртгэлийн гэрчилгээнд салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Малын эмийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж салбар зөвлөлийн тэмдгээр баталгаажуулна.

2.13. Малын эмийн салбар зөвлөл тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн бичиг баримтын сан үүсгэн, холбогдох хуулийн дагуу хадгалж ашиглана.

Гурав. Тэжээлийн нэмэлтийг импортлох, худалдаалах, эгүүлэн татах үйл ажиллагаа

3.1. Мал, амьтны тэжээлийн нэмэлтийг импортлоход тавигдах шаардлага

- Хуулийн этгээдийн аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Үйлдвэрлэгч болон албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ
- Тэжээлийн нэмэлтийн улсын бүртгэлд бүртгэгдсэн гэрчилгээний хуулбар,
- Тэжээлийн нэмэлтийн гарал үүсэл, чанарын сертификат, тохирлын гэрчилгээ
- Үйлдвэрлэгч болон нийлүүлэгчийн /GMP, ISO/ олон улсын чанарын стандартын шаардлага хангасан гэрчилгээ

3.1.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тэжээлийн нэмэлтийг импортлох зөвшөөрөл олгоно.

3.1.2. Тэжээлийн нэмэлтийн импортын лиценз олгох журмыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

3.1.3. Тэжээлийн нэмэлтийн импортын лицензийн загварыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

3.1.4. Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн дагуу олон улсын төсөл, хөтөлбөр, тусламж, хандив, зээлийн шугамаар нийлүүлэгдэж байгаа тэжээлийн нэмэлт нь Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас албан бичиг авсан байна.

3.1.5. Энэхүү журмын 3.1.-д заасан бичиг баримтыг хүлээн авснаас хойш ажлын 5 хүртэл хоногт багтаан Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас импортын лицензийг 1 сараас доошгүй хугацаагаар олгоно.

3.1.6. Аж ахуйн нэгж байгууллага нь лицензийг ашиглан, улсын хилээр улсын бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаажилт, тохирлын гэрчилгээгүй, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, тэжээлийн нэмэлтийг хилээр нэвтрүүлэхийг оролдсон тохиолдолд импортын лицензийг хүчингүй болгоно.

Дөрөв. Тэжээлийн нэмэлтийг худалдаалах

4.1. Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн хадгалалтын нөхцөлийг алдагдуулахгүй, төрөлжүүлэн худалдаална.

4.2. Тэжээлийн нэмэлтийг малын эмийн сан болон стандартын шаардлага хангасан хүнсний дэлгүүрт борлуулна.

Тав. Эгүүлэн татах

5.1. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, хуурамч, чанарын баталгаажуулалтгүй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, импортын лицензгүй тэжээлийн нэмэлтийг худалдаалахыг хориглож, эгүүлэн татна.

5.2. Тэжээлийн нэмэлтийн хэрэглэх зааврын мөрдөлтөнд мал эмнэлгийн салбарын улсын байцаагч хяналт тавина.

5.3. Энэхүү журмын 5.1-д заасан зөрчил илэрсэн тохиолдолд “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 25.1-д заасны дагуу эрх бүхий байгууллага дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.4. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй болон импортын лицензгүй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан тэжээлийн нэмэлтийг биологи, химийн аргаар устгах бөгөөд холбогдох зардлыг тухайн аж ахуйн нэгж хариуцна.

5.5. Шаардлагатай тохиолдолд итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, сорилтын дүн, баталгаажуулалтын дүгнэлтийг үндэслэн дараагийн шатны арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зургаа. Тэжээлийн нэмэлтийн бүртгэлийг хөтлөх, гэрчилгээжүүлэлт

6.1. Тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн асуудлыг 2.3.1, 2.3.2-д заасан шаардлагыг хангасан баримт материалыг хүлээж авснаас хойш 1 сарын дотор шийдвэрлэнэ.

6.2. Тэжээлийн нэмэлтийг бүртгэх шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор бүртгэлийн гэрчилгээг олгоно.

6.3. Бүртгэлийн гэрчилгээний хувийг хуулбарлан авч баталгаажуулан албан хэрэгцээнд ашиглана.

6.4. Улсын бүртгэлийн гэрчилгээг 5 жилийн хугацаагаар нэг хувь бичиж бүртгүүлэгчид олгоно.

6.5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн тэжээлийн нэмэлт бүрт хувийн хэрэг хөтлөнө.

6.6. Бүртгэгдсэн нэмэлтийг тухай бүр вэбсайт, хэвлэлээр нийтэд мэдээлж байна.

Долоо. Бүртгэлийн дугаар

7.1. Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн дугаар нь тухайн нэмэлтийн гарал үүсэл, бүртгэгдсэн он, бүртгэлийн хүчинтэй хугацаа (он сараар), нэмэлтийг олгох нөхцөл, хувийн дугаарыг агуулна.

7.2. Улсын бүртгэлд бүртгэгдсэн тэжээлийн нэмэлтийг дараах загвараар дугаарлана. /QF-15-0220-A-O-99999/

7.3. Малын тэжээлийн нэмэлтийн бүртгэлийг дугаарлахад нэр томъёоны дараах товчлолыг ашиглана.

Үүнд:
Товчлол Тайлбар
Эх үүсвэр

**ДОТООДОД ҮЙЛДВЭРЛЭСЭН ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ
APPLICATION FORM FOR REGISTRATION OF FEED SUPPLEMENT PRODUCTS**

Өргөдлийн хэлбэр (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)

Type of application (check the box applicabel)

Шинээр бүртгүүлэх

New registration

Бүртгэлд өөрчлөлт оруулах

Changes to an existing registration

Сунгуулах

Renewal of registration

I ХЭСЭГ.

PART I ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.

Өргөдөл гаргагч нь тухайн үйлдвэрийг Монгол улсад төлөөлөх эрхтэй төлөөлөгчийн газартай эсвэл тус үйлдвэртэй тодорхой тэжээлийн нэмэлтийг худалдах, бүртгүүлэх гэрээ байгуулсан Монгол улсын аж ахуйн нэгж байгууллага байна.

Applicant's Information

The applicant shall be an official representative of a foreign manufacturer in Mongolia, or a Mongolian wholesaler who has a contract with the manufacturer on registration of feed supplement product(s)

Байгууллагын нэр

Name of organization

Байгууллагын хаяг

Business address

Шуудангийн хаяг

Postal address

Утасны дугаар

Telephone number

Факсын дугаар

Fax number

Е-мэйлхаяг

E-mail address

Харилцах хүн

Contact person

II ХЭСЭГ.

PART II ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Manufacturer information

Нэр

Name

Шуудангийн хаяг

Postal address

Утасны дугаар

Telephone number

Факсын дугаар

Fax number

Вэб хаяг

Web address

Харилцах хүн
Contact person
E-мэйл хаяг
E-mail address

III ХЭСЭГ.

PART III ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ
INFORMATION OF FEED SUPPLEMENT PRODUCTS

Тэжээлийн нэмэлтийн нэр
name of the feed supplement products

Хэлбэр
form

Хадгалах нөхцөл
Storage condition

Хүчинтэй хугацаа
Shelf life

Савлагаа

Primary packaging

Савлалтын хэмжээ (нэгж ба бөөнөөр савласан)

Packing size (unit and bulk package)

..... (нэр) миний Монгол улсын мал, амьтны тэжээлийн нэмэлтийг
бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн бүх баримт бичиг, өргөдөл нь үнэн бөгөөд эх
хувь мөн болно.

.....Гарын үсэг

.....онсарөдөр

I declare that the particulars given in this application are true and correct,
and that all accompanying reports and documents provided for the registration of animal
feed supplement in MONGOLIA are true and are authentic correct.

Date..... Authorized signature.....

Address

Council of Drugs & Biopreparations

Department of Veterinary

Enkh taivan Street

Ulaanbaatar

Mongolia.

ИМПОРТЫН ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ
APPLICATION FORM FOR REGISTRATION OF FEED SUPPLEMENT PRODUCTS

Өргөдлийн хэлбэр(холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)

Type of application (check the box applicabel)

Шинээр бүртгүүлэх

New registration

Бүртгэлд өөрчлөлт оруулах

Changes to an existing registration

Сунгуулах

Renewal of registration

Өргөдлийн 1-хэсгээс бусдыг Англи хэл дээр зөвхөн үйлдвэрлэгч бөглөнө. (To be filled in English by manufacturer only except Part-I)

I ХЭСЭГ.

PART I ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.

Өргөдөл гаргагч нь тухайн үйлдвэрийг Монгол улсад төлөөлөх эрхтэй төлөөлөгчийн газар эсвэл үйлдвэртэй тодорхой тэжээлийн нэмэлтийг худалдах, бүртгүүлэх гэрээ байгуулсан Монгол улсын аж ахуйн нэгж байгууллага байна.

Applicant's Information

The applicant shall be an official representative of a foreign manufacturer in Mongolia, or a Mongolian wholesaler who has a contract with the manufacturer on registration of feed supplement product(s)

Байгууллагын нэр

Name of organization

Байгууллагын хаяг

Business address

Шуудангийн хаяг

Postal address

Утасны дугаар

Telephone number

Факсын дугаар

Fax number

Е-мэйл хаяг

E-mail address

Харилцах хүн

Contact person

II ХЭСЭГ.

PART II ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Manufacturer information

Нэр

Name

Шуудангийн хаяг

Postal address

Утасны дугаар

Telephone number

Факсын дугаар

Fax number

Вэб хаяг

Web address
Харилцах хүн
Contact person
E-мэйлхаяг
E-mail address

III ХЭСЭГ.

PART III ТЭЖЭЭЛИЙННЭМЭЛТИЙН ТАЛААРХМЭДЭЭЛЭЛ
INFORMATION OF FEED SUPPLEMENTPRODUCTS

Тэжээлийн нэмэлтийн нэр
name of the feed supplement products

Хэлбэр
form

Хадгалах нөхцөл
Storage condition

Хүчинтэй хугацаа
Shelf life

Савлагаа

Primary packaging

Савлалтын хэмжээ (нэгж ба бөөнөөр савласан)

Packing size (unit and bulk package)

..... (нэр) миний Монгол улсын мал, амьтны тэжээлийн нэмэлтийг бүртгэлд
бүртгүүлэхээр ирүүлсэн бү баримт бичиг, өргөдөл нь үнэн бөгөөд эх хувь мөн
болно.

.....Гарынүсэгонсарөдөр

I declare that the particulars given in this application are true and correct, and that
all accompanying reports and documents provided for the registration of animal feed
supplementin MONGOLIA are true and are authentic correct.

Date..... Authorized signature.....

Address
Council of Drugs & Biopreparations
Department of Veterinary
Enkh taivan Street
Ulaanbaatar
Mongolia.